

## ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААН ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГА

*Н. Нямдорж*  
Доктор (Ph. D.)

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль*  
*Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

nyamaa89@gmail.com

*Э. Мөнгөнтулга*

*Монгол улсын боловсролын их сургууль*  
*Математик, байгалийн ухааны сургууль*

mengee5gmail.com

*Хураангуй:* Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11-д “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй...”-г тунхаглан, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг бүрдүүлсэн байна. Тус хуулийн 14-р зүйлд Гэр бүлийн харилцаан дахь эхнэр нөхөр, хамтын амьдралтай байгаа хүнээ мэргэжлээрээ ажиллах, эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэх, гэрлэлтийн гэрээ байгуулах, өөрчлөх, гэр бүлийн харилцаанд оролцох зэрэг хүний эрх, эрх чөлөөг зөрчихийг тус тус хориглосон байдаг билээ. Мөн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гэр бүлийн гишүүнд ногдох хувь хөрөнгийг тогтооход оролцох, түүнийг захиран зарцуулах, орлого олох, гэр бүлийн бусад хэрэгцээг хангах үйл ажиллагаа явуулах, гэр ахуйн ажил ба өрхийн аж ахуй эрхэлсэн, хүүхэд, ахмад настныг асарсан зэрэг гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлгээг нийгмийн баялаг бүтээх болон өрхийн эдийн засагт оруулсан хувь хэмээн тооцоно хэмээн хуульчилсан байна.

*Түлхүүр үгс:* Жендер, гэр бүл, эрх тэгш байдал

### УДИРТГАЛ

Гэр бүлийн харилцаан дахь жендэр ба хүний эрхийн асуудалд нийгмийн зүгээс анхаарал хандуулан хуулийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх, цаашдын зорилтыг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх хууль тогтоомжийн зохицуулалт,

бодлогын баримт бичиг, төрийн байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилт, жендэрийн тэгш байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, хүний эрхийн асуудалд дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж боловсруулах, улмаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний

эрхийн талаар тусгаж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхийг зорино.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны мэдээлэл

цуглуулалт

Судалгааны ажлын зорилгоо хангахын тулд судалгааны нийтлэг арга болох задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ажиглах, харьцуулах, логик анализын зэрэг нийтлэг ерөнхий аргуудаас гадна системийн хандлагын арга, социологийн санал асуулга, чанарын судалгааны арга, прагматик хэрэглээний аргуудыг хэрэглэсэн.

Судалгааны мэдээллийг нийгмийн судалгааны мэдээлэл цуглуулах дараах аргуудаар цуглууллаа. Үүнд:

- ✓ Анкет буюу санал асуулгын арга;
- ✓ Ганцаарчилсан ярилцлагын арга;
- ✓ Баримт бичиг шинжлэх аргуудаар тус тус судалгааны үндсэн мэдээллүүдийг цуглуулсан.

Судалгааны түүвэрлэлт

Судалгааны ажлын цар хүрээний хувьд санал асуулгын судалгааг Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол, Сонгинохайрхан, Багануур дүүрэг, 3 бүсийн Өмнөговь, Дундговь, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудын 450 хүнээс авч, анхан шатны 4 шүүх /Нийслэлээс 2 дүүргийн шүүх, орон нутгаас 2 аймгийн шүүх/-ийг хамруулан судалсан.

Санал асуулгад хамрагдах хүнийг санамсаргүй байдлаар сонгохдоо түүврийн бүтэц алдагдахаас сэргийлэх арга хэмжээг авсан. Судалгаанд нийгмийн бүлгүүдийн тэгш төлөөллийг хамруулах зорилт тавих болно. Үүнд нас, хүйс, боловсролын түвшин, хот, хөдөө амьдардаг байдал гэх мэт нийгмийн олон үзүүлэлтээр төлөөллийг хангасан түүврийн бүтцийг бүрдүүлсэн.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд оролцогчдын нийгмийн шинж байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 1: Улаанбаатар, аймгуудаас судалгаанд оролцогчдын насны байдал*


		Улаанбаатар хот (хувь)	Аймгууд (хувь)
Нас	18-19 нас	5.0	1.4
	20-29 нас	47.0	32.0
	30-39 нас	26.0	41.5
	40-49 нас	11.0	14.1
	50-59 нас	8.0	7.7
	60+	3.0	3.2
	Нийт	100.0	100.0

Хүснэгт 1-ээс харахад бүх насны тэгш төлөөлөл судалгаанд жигд хамрагдсан нь харагдсан байна.

Улаанбаатар хот болон аймгуудаас судалгаанд оролцогчдын нийгэм хүн

амзүйн шинж байдал буюу түүврийн төлөөлөх чадвар төлөвлөлтөөс зөрүүтэй биш байна. Судалгаанд насны бүлгүүдийн тэгш төлөөлөл хамрагдаж чадсан байна. /Хүснэгт 1 үзнэ үү/

График 1. Улаанбаатар хот болон аймгуудын судалгаанд оролцогчдын хүйсийн байдал



Хүйсийн хувьд санамсаргүй түүвэрлэлтээс шалтгаалан анхны төлөвлөлтөд судалгааны нийт үр дүнд сөрөг нөлөө үзүүлэхүйц хазайлт биш гэж үзэж байна.

Харин судалгаанд оролцогчдын боловсролын түвшин жигд тархалттай байна. 5,4 хувь нь магистр болон докторын зэрэгтэй, 42.1 хувь нь бакалаврын дээд боловсролтой, 6.9 хувь нь тусгай

мэргэжлийн дунд боловсролтой, 3.45 хувь нь техник мэргэжлийн боловсролтой, 29,8 хувь нь бүрэн дунд, 6.4 хувь нь суурь, 2.0 хувь нь бага, 4.95 хувь нь боловсролгүй иргэд байна.

Мөн судалгаанд оролцогчид ажил эрхлэлтийн хувь төрөл бүрийн салбарын төлөөлөл болж чадахуйц тархалттай хамрагдсан байна /Хүснэгт 1.2/

Хүснэгт 2. Улаанбаатар хот, сонгогдсон аймгуудаас судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал	Улаанбаатар хот (хувь)	Аймгууд (хувь)
Төрийн байгууллага	28.0	41.2
Төрийн бус байгууллага	17.0	8.8
Хувиараа хөдөлмөр эрхлэдэг	28.0	22.5
Оюутан	20.0	1.0
Гэрийн ажилтай /аж ахуй эрхэлдэг/	1.0	2.0
Тэтгэвэрт	3.0	7.8
Ажилгүй	2.0	16.7
Ажилгүй /хөдөлмөрийн чадвараа алдсан/	1.0	2.0
Нийт	100.0	100.0

Энэхүү судалгаанд төрийн албан хаагч нар нэлээд хувийг эзэлсэн нь судалгааны мэдээллийн чанарт илүү өгөөжтэй байсан гэж дүгнэж байна. Оролцогчдын ажил эрхлэлтийн байдал түүврийн хувьд

хэвийн тархалттай байгаа нь судалгааны мэдээллийн чанарт сайнаар нөлөөлсөн гэж болно. Жич: Гэрийн ажилтай гэдэг нь өөрийн гэртээ аж ахуй эрхэлдэг гэсэн үг болно.

<i>Хүснэгт 3. Улаанбаатар хот болон сонгогдсон аймгуудын судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал</i>	Улаанбаатар хот (хувь)	Аймгууд (хувь)
Гэрлэлтээ батлуулсан	44.0	59.4
Гэрлэлтээ батлуулаагүй	30.0	24.6
Салсан /Цуцалсан	3.0	1.7
Бэлбэсэн	2.0	0.7
Тусгаарласан	3.0	3.0
Огт гэрлээгүй	18.9	9.8
Бусад...	2.0	0.7
Нийт	100.0	100.0

Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал нь төлөөлөл болохуйц тархалттай байсан. Гэр бүлээ батлуулсан гэр бүлийн хувь 44,0-59,4 хувь байсан нь

судалгааны мэдээллийн чанарыг нэмэгдүүлэхээс гадна судалгааны зорилгыг хангсан гэж судалгааны баг үзсэн болно.

*График 3. Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэр*




График 4. Аймгуудын судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэр



Судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэрийг Улаанбаатар хот болон аймгуудын хувьд харьцуулахад ерөнхийдөө ойролцоо байна. Харин бусад орлогын хувьд аймгуудын оролцогчдын хувь нь 10 хувиар илүү байлаа. Орлого олох боломж нь аймгуудынх илүү гэж үзсэн байна.

Судалгаанд оролцогчдын 16% нь хүүхэдгүй, 33% нь 0-3 насны хүүхэдтэй, 38% нь 4-12 насны хүүхэдтэй, 13% нь 13-насны хүүхэдтэй, 0,1% буюу нэг гэр бүл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлүүд байлаа.

0-3 настай хүүхэдтэй гэр бүлийн боловсролын байдлыг хамаарлыг үзвэл 60 гаруй хувь нь бүрэн дунд боловсролоос дээш боловсролын зэрэгтэй гэр бүлүүд судалгаанд оролцсон байна.

Гэр бүлийн харилцаан дахь Жендерийн эрх тэгш байдлын тухай зургаан зүйл заалтын ойлголтуудыг Гэр бүлийн гишүүдээс асуухад Гэрлэгчид болон хамтран амьдрагч нарын эрхийн асуудал, Хамтын хөрөнгийн тухай, Өрхийн хөдөлмөр эрхлэлт болон өрхийн эдийн

засгийн ойлголтуудыг мэдэхгүй гэж 40 гаруй хувь хариулсан нь энэ чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага байгааг харуулж байна. Харин гэр бүл төлөвлөлт болон гэр бүлийн үүрэг хариуцлагын талаар мэднэ гэж 44,6-49,5 хувь хариулсан байгаа нь энэ талын ойлголт, мэдлэг тодорхой хэмжээгээр байгааг илтгэж байна. Эдгээр ойлголтуудын мэдлэгийн үнэлгээ нь энэхүү судалгааны мэдээллийн чанарт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгааг илтгэнэ.

Гэр бүлтэй байх, гэр бүлгүй байх, хамтын амьдралтай байх Жендерийн эрх тэгш байдлын заалтын хэрэгжилтийн байдлыг /нийгмийн салбарууд/ асуухад Улаанбаатар хотын судалгаанд оролцсон 130 иргэдээс асуусан бөгөөд Гэр бүлтэй байх, гэр бүлгүй байх, хамтын амьдралтай байх Жендерийн эрх тэгш байдлын заалтын хэрэгжилт нийгмийн салбаруудад хэр зэрэг хангагдсан тухай асуухад судалгаанд оролцогчдын Гэр бүлийн түвшинд,

Эрүүл мэндийн салбарт, Нийгмийн халамж, хамгаалалд “Маш сайн” хангагдсан гэж үнэлсэн бол, Батлан хамгаалах, хүчний салбар, Барилгын салбар, Сэтгүүл зүйн, Шүүх засаглал гэсэн салбаруудад “муу”, Улс төр, Уул уурхайн

салбарт “маш муу” гэсэн үнэлгээ авсан нь жендерийн эрх тэгш байдал хангагдаагүй гэсэн нь судлаачдын хувьд өнөөгийн байдалтай нийцэж байгаа гэж үзэж байна.



Гэрлэгчид болон хамтран амьдрагчид нэгнийгээ мэргэжлээрээ ажиллах, бусад хэлбэрээр нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох эрхийг хязгаарлах, саад учруулахыг хуулиар хориглодог талаар Та

мэдэх үү? асуултад судалгаанд оролцогчдын 50,3% нь мэдэхгүй, 12,0% сонсож байсан, 1,8% хариулаагүй нь хуулийн энэхүү заалтын хэрэгжилт бодит амьдралд хангалтгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 9. Гэр бүлийн харилцаан дахь Жендерийн эрх тэгш байдлын нөлөөлөл	ТИЙМ	ҮГҮЙ	МЭДЭХГҮЙ
Гэр бүл салалт буурна	83.5	4.1	12.4
Гэр бүлийн хүчирхийлэл буурна	80.6	9.2	1.2
Гэр бүлийн гишүүдийн хорт бодис, зуршлын хэрэглээ буурна	63.9	14.4	21.6
Гэр бүл төлөвлөлт сайжирна	81.4	13.4	5.2
Гэр бүлийн гишүүдийн харилцаа сайжирна	89.6	5.2	5.2
Гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээ сайжирна	76.3	7.2	16.5
Гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ	80.4	7.2	12.4
Гэр бүлийн талаарх бодлого, хууль сайжирна	68.0	9.3	22.7
Гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлага нэмэгдэнэ	84.4	8.3	7.3
Нийгмийн бүхий л харилцаанд гэр бүлийн үнэ цэнэ өснө	74.2	12.4	13.4
Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүний нөхцөл байдал сайжирна	67.0	7.4	25.5

Гэр бүлийн харилцаан дахь Жендерийн эрх тэгш байдлын нөлөөлөл ерөнхийдөө эерэг байхыг судалгаанд оролцогчид үнэлсэн бөгөөд эндээс гэр бүлийн гишүүдийн хорт бодис, зуршлын хэрэглээ, гэр бүлийн талаарх хууль бодлого, Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүний нөхцөл байдал сайжруулах тал дээр анхаарлаа хандуулах ёстойг харуулж байна.

Гэр бүлийн харилцаан дах жендерийн эрх тэгш байдлыг баталгаажуулахад хэн голлох үүрэг,

давуу эрхтэйгээр аливаа асуудлыг шийдвэрлэдэг талаар асуухад нөхөр гэж 56,5%, эхнэр гэж 43,5% нь хариулсан байна.

Гэр бүл болсны дараа цаашид мэргэжлээрээ ажиллах боломжтой эсэхийг асуухад 89,5 нь ТИЙМ, 5,6% нь ҮГҮЙ гэсэн сонголтыг хийсэн байна. Үүнээс эрэгтэй эмэгтэй хүйсийн хувьд хэрхэн хариулсанг үзвэл эрэгтэйчүүдийн 8%, эмэгтэйчүүдийн 15% нь гэр бүл болсны дараа мэргэжлээрээ ажиллах боломжгүй гэсэн хариулт өгсөн байна.



Үүний шалтгаан нь эхнэр, нөхрийн хардалт, хяналт-14,6%, нөхрийн болон эхнэрийн ажлын онцлог, шаардлагаар-36,4%, хүүхдийн сургууль цэцэрлэгийн хүртээмжгүй байдал-9,2%, гэр бүлийн гишүүдээ хамгаалахын хажуугаар хийх цагийн ажил хомс-

22,3%, эрүүл мэндийн байдал-22,3%, шилжилт хөдөлгөөн-23,3%, хадмуудын харилцаа-4,9% бусад гэж 12,6 нь хариултуудыг өгсөн байна. Тэгэхээр бидний судалгааны таамаглалд энэ үр дүн ямар нэг хэмжээгээр амьдралд оршин байгааг харуулж байна.

Эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэх, гэрлэлтийн гэрээ байгуулах, өөрчлөх, гэрлэлтээ сайн дураараа цуцлуулах, хүүхдээ хамтран өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн харилцаанд оролцох зэрэг хүний эрх, эрх чөлөөг зөрчихийг хуулиар хориглодог талаар Та мэдэх үү?



Эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэх, гэрлэлтийн гэрээ байгуулах, өөрчлөх, гэрлэлтээ сайн дураараа цуцлуулах, хүүхдээ хамтран өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн харилцаанд оролцох зэрэг хүний эрх, эрх чөлөөг зөрчихийг хуулиар

хориглодог талаар Та мэдэх үү? асуултад судалгаанд оролцогчдын үнэлэмж ойролцоо байгаа нь сайшаалтай бөгөөд гэрлэлтийн гэрээний тухай ойлголтод олон нийтэд хүрсэн байгааг илэрхийлж байна.

График 8. Гэр бүл болж ханиа сонгох шийдвэрт нөлөөлж буй хүчин зүйл



Гэр бүл болоход хамгийн ихээр нөлөөлж буй хүчин зүйл бол ХАЙР СЭТГЭЛ гэдгийг судалгаанд оролцогчдын 66,4% хүлээн зөвшөөрсөн нь голлох хүчин зүйл мөн гэдгийг хүлээн зөвшөөрсөн явдал юм. Бусад хүчин зүйлүүд ижил тархалттай байлаа. Хамаатан садны, Гэрлэж амжаагүй, Сэтгэцийн эрүүл мэнд гэсэн хариултуудыг нээлттэйгээр өгсөн байна.

Гэрлэлтийн гэрээний тухайд судалгаанд оролцогчдын 57,1% нь зөвшөөрнө гэдэг хариулт өгсөн нь ололттой бөгөөд өнөөгийн практикт үүнийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ хувь дээр 26,5% буюу сайн мэдэхгүй байгаа гэсэн харилуу өгсөн оролцогч нарт нөлөөллийн ажил хийх саналыг хүргүүлж байна.

Гэрлэлтийн гэрээнд тусгах саналын тухайд 3,4% гэрлэлт

цуцалсны дараах үр хүүхдээ өсгөх үүрэг хариуцлагыг онцолсон анхаарал татах асуудал байлаа. Гэрлэлтийн гэрээг судалгаанд оролцогчдын 44,4% нь эд хөрөнгөтэй холбоотой маргааныг шийдвэрлэх гэж үзэж байна. Мөн судалгаанд оролцогчид “Үнэнч байдлыг хадгална гэсэн амлалт ёс зүйн тангараг юм, Олон хүн гэрлэлтийн гэрээний талаар ойлголт байдаггүй, Гэр бүлийн гадуурх харилцаа багасна.” гэсэн хариултуудыг нээлттэйгээр өгсөн байна.

Гэр бүлээ сайн дураараа цуцлуулахад ямар санал бодолтой байгаа тухайд:

- “Үнэхээр үзэл санаа нийлэхгүй бол салж болно”-41,7%,
- “Нэгэнт гэр бүл болсон бол хамтдаа амьдралаа үргэлжлүүлэх ёстой”-38,4%,
- “Гэрлэлт бол сайн дурын асуудал”-31,7%,
- “Үр хүүхдийнхээ төлөө өөрсдийнхөө хүсэл сонирхлоо өөрчлөх ёстой”-28,4% гэх мэт

Дээрх хариулт өгсөн байдал нь өнөөгийн гэр бүл болж буй хүмүүсийн үзэл бодол нь олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрөх ёстойг илэрхийлж байна. Мөн Хайр сэтгэл, үүрэг хариуцлага чухал гэдгийг судалгаанд оролцогчид чухалчлан үзэж байлаа.

График 9. Эцэг, эхчүүдийн хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүрэг хариуцлагын тухай



Үр хүүхдээ зөв, сайн иргэн болгож хүмүүжүүлэх нь эцэг, эхийн үүрэг гэдгийг судалгаанд оролцогчдын 33,0% нь хүлээн зөвшөөрч байгаа ч хэрхэн хүмүүжүүлэх арга зүйгээ олохгүй байгаа нь ажиглагдлаа.

Гэр бүл сайн дураараа цуцлалтад нөлөөлж буй өнөөгийн байдлаар гол шалтгаануудад Гэрлэх

хүнээ сайн таньж мэдээгүй /65,3%/, Архидалт, муу зуршил /36,7%/, Гэр бүлээс гадуурх харилцаа, хууралт /35,7%/, Хэрүүл маргаан, үл ойлголцол /35,7%/ голлох шалтгаанууд болсон нь өөр бусад судалгаануудын үр дүнтэй ойролцоо байгаа нь бидний судалгааны


чанарыг сайжруулж буй ач холбогдолтой юм.

Гэрлэлт, гэр бүл цуцлалттай холбоотой гардаг хүний эрхийн зөрчлийн талаар асуухад судалгаанд оролцогчид дараах хариултуудыг өгсөн байна. Үүнд:

- Хүний эрхийн зарим заалт зөрчигддөг
- Ээжийн талд шийдэгддэг,
- Хүйсийн харилцаа зөрчигддөг,

- Өөртөө итгэх итгэл буурдаг,
- Хүүхдээ үл хайхардаг,
- Хардалт,
- Боловсролоор дээрэлхэх,
- Хүүхдийн эрх хүний эрх зөрчил,
- Сэтгэл санааны болон эдийн засгийн байдал доройтдог гэдгийг дурдсан байна.

График 10. Гэр бүл салалтын дараа хүүхэд болон эцэг эхийн харилцаанд гарах асуудал



Гэр бүл салалтын дараа хүүхэд болон эцэг эхийн харилцаанд гардаг асуудлуудаас 53,1% нь хүүхдээ ҮЛ ХАЙХРАХ БАЙДАЛ гардаг гэж хариулсан нь

гэр бүл салалтын үр дагаварт хүүхэд хохирдог гэдгээр батлагдаж буй явдал юм. Үүнийг ярилцлагын явцад судалгаанд оролцогчид баталсан юм.



Судалгаанд оролцогчдын Үлдсэн хувь нь мэдэхгүй, сонсож байсан, хариулаагүй нь энэ талаарх 46,5% мэднэ гэж хариулт өгсөн.

мэдлэг сөрөг тал руу байгааг харуулж байна.

Өнөө үед гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэгийг 34,8% нь цахим орчноос, 21,5% нь эцэг эхээс олж авч байгааг дурдсан байна. Иймээс энэ мэдээллийн сувгуудыг ашиглан нөлөөллийн үйл ажиллагааг явуулах нь үр дүнтэй байгааг нотлож байна. Гэр бүл төлөвлөлтийн мэдээллийг цахим орчинг ашиглан зөв мэдлэг түгээх нь өнөө үед чухал мэдээллийн тогтолцоог болсонг харуулж байна.

Эхнэр, нөхөр хамтдаа ижил оролцоотойгоор харилцан ярилцаж шийдвэр гаргадаг гэж 68,3% нь хариулсан нь гэр бүл дэх жендерийн эрх тэгш байдал тодорхой хэмжээгээр хэрэгждэг гэж судлаачийн хувьд үзэж байна. Гэхдээ үүнд нөлөөлж буй олон

хүчин зүйл байгааг цаашид судлах шаардлага байгааг судалгааны мэдээлэл цуглуулах явцад ажиглагдсан болно. Ерөөсөө төлөвлөхгүй, хамтран шийдэхгүй байгаа шалтгаанаа судалгаанд оролцогчид залуучууд ер нь төлөвлөдөггүй, хамтран шийддэггүй, харилцан ойлголцол муу, гэр бүлийн боловсрол муу, төлөвлөлт тийм чухал биш гэж үзсэн байна.

Бакалаврын болон бүрэн дунд боловсролтой оролцогчдын хариултууд хүүхэдтэй болох асуудалд тлүү нухацтай хандаж буйг харж болно. Иймээс боловсролын байдал болон хүүхэдтэй болох асуудал хоёрын хооронд хамаарал байгааг харуулж байна.



Хүүхдийн хүмүүжлийн асуудалд эцэг, эхчүүдийн үүрэг, хариуцлага, оролцооны талаарх жендерийн эрх тэгш байдлын талаарх судалгаанд оролцогчдын хариулт, үнэлэмж ойролцоо байгаа нь сайшаалтай юм. Учир нь

мэдэхгүй гэсэн хариултаас сонсож байсан нь илүү хувьтай байна.

Өнөөгийн нийгэмд эцэг эхчүүд хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, асран хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах, үүргээ биелүүлж буй байдал нь харилцан адилгүй гэж

36,7% нь хариулжээ. Тэгэхээр гэр бүлийн үүрэг, оролцоо хүүхдээ өсгөх, хүүмүүжүүлэх тал дээр ямар нэг хэмжээгээр дутмаг байгааг харуулсан гэж үзэж байна.

Эцэг эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа дараах шалтгаануудыг нэрлэсэн байна.


Үүнд:

- Ажил ихтэй гэр бүлдээ анхаарал тавьдаггүй
- Хариуцлагагүй байдал хавтгайрсан
- Архидалт ядуурал их байна.

- Улс орны нийгэм эдийн засгийн хүнд байдал
- Суурь хүмүүжил муу
- Салалт их байгаагаас
- Хувь хүний хүмүүжлээс шалтгаалж байсан гэсэн байна.

Судалгаанд оролцогчид Эцэг эхийн зүгээс гэр бүлдээ үзүүлэх үүргээ хэрхэн биелүүлж байгаа байдалд “Дундаж” үнэлгээг өгсөн байна. Үүнээс дүгнэж үзвэл эцэг эхчүүд үүргээ хариуцлагатай биелүүлэх шаардлага байгааг харуулж байна.

График 13. Эцэг, эх хүүхдээ асран хамгаалахтай холбоотой өнөөгийн нийгэмд гарч буй асуудал



Эцэг эхийн үр хүүхдээ асран хамгаалах үүргээ биелүүлээгүйгээс болж гарч буй хамгийн тулгамдсан асуудал бол Хүүхдээ үл хайхрах байдал юм. Үүний улмаас хүүхэд боловсрол, эрүүл мэндийн талаар асуудалтай болж байгааг судалгаануудын үр дүнгээс харж болно. Сүүлийн жилүүдэд бий болсон эдийн засгийн хүндрэлээс шалтгаалж хүүхэд хөдөлмөр

эрхлэх, тавиул хүүхдийн асуудал нэмэгдсэн байна.

Хүүхдийн хүмүүжлийн асуудалд гэр бүлийн гишүүдийн оролцоо нь хамтын шийдвэр гаргах асуудал дээр 42 % нь оролцдог гэж хариулсан сайшаалтай. Оролцооны шатлалын хувьд шийдвэр гаргах нь хамгийн чухал оролцоо гэж үздэг.

Судалгаанд оролцогчдоос хүүхдээ цаг гаргадаг гэсэн асуултыг

тавихад тийм гэж 57% нь, үгүй 28% нь, мэдэхгүй болон хариулаагүй 15% нь хариулжээ. Үүнийг учир шалтгаан нь ажил ихтэй гэж 32,5%, цаг гардаггүй гэж 3,1% хариулжээ. Мөн гэр бүл салсан, хөгшин болсон, амралтын өдрөө амармаар байдаг, чөлөөт цаг хязгаарлагдмал гэх мэт хариултуудыг өгсөн байна.

Хүүхдээ асран хүмүүжүүлэхэд төр засгаас авах

График 14. Гэр бүлийн хэв маягт гарч буй өөрчлөлтийн талаар




Олон соёлт гэр бүл бий болох, ганц биеэр амьдрах буюу гэр бүл зохиохгүй байх бодол санаатай нэгэн үе бий болж байгааг судалгааны үр дүнгээс харж болох юм. Учир нь өнөөгийн залуусын дунд гадаад хүнтэй гэрлэх сонирхол нэмэгдсэн. Үүнийг судалгаанд

арга хэмжээний тухай асуухал судалгаанд оролцогчдын 64,7% нь ямар нэг хариулт өгөөгүй байна. Иймээс хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хариуцлагатай хандах шаардлага байна. Хамгийн чухал хүүхэд, гэр бүлийг дэмжих асуудалд илүүтэй анхаараасай гэж 18,2% нь саналаа өгчээ.

оролцогчдын хүйсийн хувьд энэ асуудалд хэрхэн хандсан хамаарлыг үзвэл эрэгтэйчүүд илүүтэй сонгосон байна. Ганц биеэр амьдрах буюу гэрлэх хүсэлгүй гэсэн хариултыг судалгаанд оролцогчдын хувьд эрэгтэйчүүд давамгайлсан байна.

График 15. Гэр бүлийн гишүүдийн хоорондын маргаан болон гэр бүлийн хүчирхийллийн ялгаа



Энэхүү асуултад судалгаанд оролцогчдын 42% хүчирхийлэл бол тэнцвэргүй харилцаа, айдас юм гэсэн нь Хүчирхийлэл болон маргааны ялгааг тодорхой хэмжээгээр мэдэж байгаа нь сайшаалтай. Аливаа гэр бүлийн хөгжил нь маргааны явцад шийдэл хүрэх замаар хөгждөг зүй тогтолтой гэж үзсэн байна.

Гэр бүлийн боловсролыг олгохдоо хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан мэргэжлийн хүний нөөцийн оролцоотойгоор зөв мэдлэг ойлголтыг өгөх ёстой гэсэн саналыг хэлсэн болно. Сургалтын байгууллагын үүрэг оролцоо үүнд ихээхэн хувь нэмэртэйг онцлон тэмдэглэх нь зүйтэй.



Дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гэр бүлийн гишүүнд ногдох хувь хөрөнгийг тогтооход оролцох, түүнийг захиран зарцуулах, орлого олох, гэр бүлийн бусад хэрэгцээг хангах үйл ажиллагаа явуулах гэр бүлийн гишүүний эрхийг хүйсийн шинжээр хязгаарлаж үл болно гэдэг заалтыг Та мэдэх үү? асуултад судалгаанд оролцогчдын 51,5% нь мэдэхгүй байгаа нь энэхүү хуулийн заалт нь бодит амьдралд хэрэгжилт хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Гэр бүлийн хүрээнд эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой асуудалд судалгаанд оролцогчдын 23,5% нь цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах


орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, 15% нь орлого олох боломжийг нь хязгаарлах, 14,1% нь шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, 7% нь тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулах, 3,3% нь хөрөнгийн хохирол учруулах зэрэг асуудлууд гардаг гэж хариулжээ. Гэрр бүлийн гишүүдийн дунд хөдөлмөрлөх эрх болон эдийн засгийн эрх чөлөөнд гардаг асуудал бол гишүүний олсон орлого болох цалин хөлс, түүнтэй адилтгах орлоготой холбоотой маргаан гарах явдал байсаар байна. Үүнээс болж гэр бүлийн маргаан,

хүчирхийлэл гарах нөхцөл болдог гэж оролцогчид хариулсан.

Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ эдлэхдээ хүйсийн шинжээр хязгаарлуулж байсан тухайд судалгаанд оролцогчдын 84,1% үгүй, 10,7% нь зарим тохиодолд, 5,2% тийм гэсэн хариултуудыг өгсөн. Энэ нь гэр

бүлд эдийн засгийн хүчирхийлэл ямар нэг хэмжээгээр оршин буйг илтгэж байна.


Гэр бүлийн дундын өмч, гишүүдийн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ эдлэхэд гэр бүлийн гишүүдийн хэн нь давамгайл эрхтэй байгааг асуухад дараах хариултуудыг өгсөн байна. Үүнд:



Үүнээс дүгнэж үзвэл өнөөгийн гэр бүлд эмэгтэйчүүд илүү эдийн засгийн хувьд захиран зарцуулах эрхийг эдэлж байгааг харж болно.

Үүнтэй холбоотойгоор гэр бүлийн хүрээнд эд хөрөнгийг

захиран зарцуулах, ашиглах, эзэмшихтэй холбоотой маргаан гарч байсан уу? гэхэд үгүй гэж 88,9%, хааяа гэж 11,1% нь хариулсан.



Эхнэр, нөхрийн гэрлэснээс хойш гэр ахуйн ажил ба өрхийн аж ахуй эрхэлсэн, хүүхэд, ахмад настныг асарсан зэрэг гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлгээг нийгмийн баялаг бүтээх болон өрхийн эдийн засагт оруулсан хувь хэмээн тооцох талаар Та мэдэх үү? асуултад 51,5% нь мэдэхгүй гэсэн нь өнөөгийн практикт гэр бүлийн гишүүдийн мэдлэг хангалтгүй байгааг харуулж байна. Гэвч өрхийн аж ахуйг дэмжих явдал чухал гэдгийг судалгааны явцад хийгдэж байсан ярилцлагад онцолж байсан болно.

Гэрийн ажил буюу хөлсгүй хөдөлмөрт ээжүүд болон хадам аав, ээж нар хамгийн их оролцоотой байгаа гэж судалгаанд оролцогчдын 81,8% нь үзжээ. Энэ хүмүүсийн хөдөлмөрийг үнэлэх Асрахуйн эдийн засгийн ойлголтыг хөгжүүлэх шаардлага байна. Гэр бүлийн гишүүдийн хөлсгүй хөдөлмөрийг

үнэлэх нь амьдралд ач холбогдолтой талаар нээлттэй асуухад хөдөлмөрийг үнэлэх нь зөв, хийх ёстой ажлаа хийж байгаа, ажлын бүтээмж дээшилэнэ, сэтгэл санааны дэмжлэг авна, ямарч ач холбогдолгүй гэх мэт хариултуудыг өгч байлаа. Үүнтэй холбоотой Цалинтай ээж, гэрээр асаргаа үзүүлэх үйлчилгээ зэргийг улам сайжруулж, боловсронгуй болгох шаардлага байна.

Ажил-гэр бүлийн зохистой тэнцвэрийг хангах байдал дээр судалгаанд оролцогчдын тийм гэж 83,6%, үгүй гэж 16,4% хариулсан бөгөөд ихэнх нь аль болох тэнцвэртэй авч явахыг хичээдэг байна. Үгүй гэж хариулсан оролцогчдын хувьд байгууллагын зүгээс анхаардаггүй-11,6%, ажлын хатуу цагтай-52,5%, энэ талаар бодож байгаагүй-37,0% нь дээрх шалтгаануудыг илэрхийлсэн байна.

График 20. Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийг хангахад төр засгийн зүгээс хийх үйл ажиллагаанд өгөх санал



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг бүрдүүлэхэд төр засгийн зүгээс судалгаанд оролцогчдын хамгийн ихээр хүсэж буй асуудал бол Гэр бүлийн боловсрол олгох нөхцөл боломж, дэмжлэг, Гэр бүлд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, боловсхонгуй болгох тал дээр илүү ихээр анхаарч, ач холбогдол өгч ажиллахыг хүсэж байгаагаа энэхүү судалгааны явцад илэрхийлсэн болно.

### **САНАЛ ЗӨВЛӨМЖ**

❖ Гэрлэгчид, төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүн ямар нэг байдлаар эхнэр, нөхөр, хамтын амьдралтай байгаа хүнээ мэргэжлээрээ ажиллах, бусад хэлбэрээр нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох эрхийг хязгаарлах, саад учруулахыг хориглох тухай судалгаанд оролцогчдын 44,9% нь мэдэхгүй байгаа нь энэ зүйлийг заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага байна. Гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжлээрээ ажиллах боломжийг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хүний хөгжлийн асуудлыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулах хэрэгтэй байна. Гэр бүл болох тухай бодол судалгаанд оролцогчдын хувьд

доогуур байгаа нь гэр бүлийн мөн чанар, гэр бүлийн боловсрол, үр удмаа үлдээх зэрэг ойлголт мэдлэг дутмаг байгааг харуулж байна. Иймээс үүнтэй холбоотой нөлөөллийн ажлуудыг хэрэгжүүлэх шаардлага өнөөгийн нийгмийн эрэлт хэрэгцээнээс гарч байна.

❖ Эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэх, гэрлэлтийн гэрээ байгуулах, өөрчлөх, гэрлэлтээ сайн дураараа цуцлуулах, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн харилцаанд оролцох зэрэг хүний эрх, эрх чөлөөний тухайд судалгаанд оролцогчдод тодорхой хэмжээгээр мэдлэг өгсөн гэж хариулсан. Энэ нь судалгааны практик ач холбогдолыг нэмэгдүүлсэн явдал юм. Гэрлэлттэй холбоотой нийгмийн олон харилцаа үүсч гарах бөгөөд үүний чухал харилцаа бол гэрлэлтийн гэрээ, гэр бүл салалт, түүнтэй холбоотой хүүхдийн асуудал билээ. Эдгээр асуудлыг эерэг байдлаар шийдвэрлэх арга замыг гадаад болон өөрийн орны өвөрмөц онцлог байдалд тулгуурлан хөгжүүлэх шаардлага байгааг дурдаж байна.

❖ Эхнэр, нөхөр нь хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацаа зэргийг хамтран шийдвэрлэх, хүсээгүй жирэмслэлтээс хамгаалах адил тэгш эрх, үүргийн тухайд судалгаанд оролцогчдын 44,6% мэдэж

байсан нь ололттой, давуу тал боловч гэр бүл төлөвлөлт, тэр дундаа хэдэн хүүхэдтэй болох, төрөлт болон нөхөн үржихүйн боловсрол мэдлэг сайн байгааг судалгааны үр дүнгээс харж болно. Энэ нь сайн байна гээд анхаарал сулруулах асуудал биш бөгөөд энэхүү асуудалд ялангуяа өсвөр, залуу үед илүү хүртээмжтэй, нээлттэй, бүтээлч, тунгаан бодох, шийдвэр гарах чадвар бүхий сургалтуудыг явуулахаас гэр бүлийн болон эрүүл мэндийн боловсрол олгоход бүх шатны боловсролын байгууллагууд бодлогоор оролцох ёстойг тэмдэглэх ёстой.

❖ Эх, эцэг хүүхэддээ нийгмийн үүрэг, хариуцлага, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын эрх тэгш оролцоо болон жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг хүйсийн шинжээр үл ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дууриал, гэр бүлийн хүмүүжлээр олгох үүргийн хувьд судалгаанд оролцогчдын 49,5% хангалттай хэмжээнд мэднэ гэж мэдлэгээ үнэлсэн юм. Гэвч мэдэхгүй байгаа үлдсэн хэсэгт бид юу хийх вэ? гэдэг асуулт байна. Өнөөдөр хүүхэд хамгааллын асуудал Монголын нийгмийн тулгамдсан асуудал хэвээр л байна. Сүүлийн сар, жилүүдэд гарсан аймшигт хэргүүдийн хохирогч хүүхэд байгаад бид санаа зовоох ёстой юм. Үүнд эцэг, эхчүүд, насанд хүрэгчдийн

үүрэг хариуцлага маш чухал гэдгийг онцлон авч үзэх ёстой. Бүгдийг төр засаг, сургууль, хүүхдийн байгууллагад даатгадаг өнөөгийн сэтгэлгээг өөрчлөх ёстой. Үүнд эцэг, эх, гэр бүлийн үүрэг оролцоо маш чухал. Гэр бүл салалт нэмэгдэж буй нь цаана хүүхэд хохирч байгааг анхаарах асуудал юм. Салсан гэр бүлийн 96% нь хүүхэд хосууд байгаа нь туйлын харамсалтай статистик билээ. Хүүхдийн хүмүүжил эцэг эх, гэр бүлийн хүмүүжлээс эхтэй. Иймээс жендэрийн тэгш байдлыг хангахад эцэг эх, үүрэг хариуцлага маш чухал бөгөөд хүнийг хүйсээр ялгаварлахгүй байх, аав ээж байх, эхнэр нөхөр байх зөв үлгэр дууриаллыг хүүхдэд үзүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ёстой. Гэр бүлд үйлчилгээ үзүүлэх бодлого, хууль, журмыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор өнөөгийн нөхцөл байдал шаардаж байна.

❖ Дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөөс гэр бүлийн гишүүнд ногдох хувь хөрөнгийг тогтооход оролцох, түүнийг захиран зарцуулах, орлого олох, гэр бүлийн бусад хэрэгцээг хангах үйл ажиллагаа явуулах гэр бүлийн гишүүний эрхийг хүйсийн шинжээр хязгаарлаж үл болох асуудалд судалгаанд оролцогчдын 42,4% нь мэдэхгүй гэж хариулсан нь анхаарал татсан, зайлшгүй шийдвэрлэх

асуудал юм. Гэр бүлийн хэлбэр маяг өөрчлөгдөж, хил хязгааргүй болж буй дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах нь Монгол хүн бүрийн үүрэг болж байгаа өнөө цагт яах вэ? гэдэг асуулт гарч байна. Олон соёлт гэр бүл, ижил хүйстэн гэр бүл, хамтран амьдрагч нар, ганц бие гэр бүлүүд бий болж байгаа нь цаад утгаараа эдийн засгийн хувьд өөрт ноогдох хөрөнгө, орлогоо хэрхэн зарцуулах асуудалд анхаарал хандуулах асуудал болж байгааг шийдвэрлэх ёстой. Үүнээс улбаалан гэр бүлд эдийн засгийн хүчирхийлэл ихээр гарах болсон статистик байна. Төр засаг энэ асуудалд нэн тэргүүн анхаарч ажиллах ёстойг судалгаанд оролцогч нар дурдаж байлаа. Ялангуяа гэр бүлийн хамтын хөрөнгөтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичиг боловсруулах шаардлага байна. Байгаа нь илүү сайжруулах, боловсронгуй болгох хэрэгтэй.

- ❖ Эхнэр, нөхрийн гэрлэснээс хойш гэр ахуйн ажил ба өрхийн аж ахуй эрхэлсэн, хүүхэд, ахмад настныг асарсан зэрэг гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлгээг нийгмийн баялаг бүтээх болон өрхийн эдийн засагт оруулсан

### **НОМ ЗҮЙ**

1. ХНХЯ,ГБХЗХГ, ADB, Green Initiative. “Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарын хүний нөөцийг чадавхжуулах” сургалтын гарын авлага. УБ., 2019.

хувь тооцох асуудалд судалгаанд оролцогчдын 40,4% мэдэхгүй гэсэн. Иймээс эхнэр, нөхрийн болон гэр бүлийн бусад гишүүдийн өрхийн аж ахуйд оруулсан хувь нэмрийг үнэлэх шаардлага орчин үеийн гэр бүлийн шийдвэрлэвэл зохих асуудал болсонг судалгааны үр дүнгээс харж болно. Уламжлалт тогтсон хандлага хэвээр л байна. Үр хүүхдээ асран хамгаалах, хүмүүжүүлэх ажил эхнэр, хадмуудын хийх ажил хэвээр байгааг судалгааны дүн харууллаа. Хөгжингүй орнуудад орчин үеийн гэр бүлд “Асрахуйн эдийн засаг” гэдэг ойлголт нэгэнт нэвтэрч буй амьдралд хэрэгжих болсон байна. Иймд бид гэрийн ажил ба өрхийн аж ахуйг дэмжсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага бий болжээ. Манай орны хувьд Цалинтай ээж, Гэрээр харах үйлчилгээ зэрэг асрахуйн эдийн засагтай холбоотой үйлчилгээнүүд бий болгосон бөгөөд үүнийг илүү ихээр дэмжиж, гэрийн аж ахуйд нэмэр болохуйц байдлаар зохион байгуулах шаардлага байгааг судалгаанд оролцогч нар онцлон тэмдэглэж байна.

2. ЖҮХ, ADB, Japan Fund for Poverty Reduction. Монгол Улсын Жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртлэх ололт амжилт ба сорилт, сургамж. УБ., 2020.

3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги

- төлөвлөгөө /2022-2031/ эмхтгэл. УБ., 2022.
4. Монгол Улсад Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь төслийн 1-р шатны АМЖИЛТЫН НОМ. УБ., 2020.
5. ЖҮХ. Жендэрийн нэр томьёо, тодорхойлолт, үндсэн ойлголтын товч тайлбар толь. УБ., 2023.
6. ЖҮХ. Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хороо. Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого. УБ., 2023.
7. Swiss Agency for Development and Cooperation. UNFPA. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. УБ., 2019.
8. ХЭҮК. Гэрлэх, гэр бүлтэй байх эрхтэй. /Хүний эрхийн түгээмэл тунхаглал/. УБ., 2023.
9. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв. Шинэ өсөлт // Эдийн засгийн төрөлжилт, тогтвортой хөгжлийн сэтгүүл. 2023. 03 сар.
10. ЖҮХ. Жендэр судлал. // Эрдэм шинжилгээний сэтгүүл. 2020. №3, 2021. №4
11. ХНХЯ. ГБХЗХГ. “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэн. Архидалтаас ангид аз жаргалтай гэр бүл /Архины хамааралтай гишүүнтэй гэр бүлд үзүүлэх үйлчилгээний арга зүй/. УБ., 2020.
12. ХНХЯ. ГБХЗХГ. Олон хэв шинжийн гэрбүлтэй ажиллах арга зүй /"Төрийн үйлчилгээнд-гэр бүлийг дэмжих хөгжлийн үйлчилгээний загвар нэвтрүүлэх нь" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын шилдэг илтгэлүүдийн эмхтгэл/. УБ., 2020